МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 сарын 17 өдөр Улаанбаатар хот

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомж

2.1.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар байгалийн ургамал, ус, ой, ан амьтны нөөцийг ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Газар болон түүний хэвлийн нөөц ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Төлбөр төлөгч, түүнийг бүртгэх

4.1.Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгч нь Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд байна.

4.2.Байгалийн нөөц ашиглах зөвшөөрөл олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

4.3.Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.

4.4.Энэ хуулийн 4.3-т заасан мэдээлэлд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, байршил, ашиглах хугацаа, хэмжээ, тоног төхөөрөмжийн хүчин чадал зэрэг шаардлагатай үзүүлэлтийг тусгана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨЛБӨР НОГДОХ ЗҮЙЛ, ҮНЭЛГЭЭГ ТОГТООХ

5 дугаар зүйл. Ургамал ашигласны төлбөр ногдох зүйл

5.1.Дараах ангиллын ургамалд төлбөр ногдуулна:

5.1.1.нэн ховор ургамал;

5.1.2.ховор ургамал;

5.1.3.элбэг ургамал.

6 дугаар зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

6.1.Дор дурдсан зориулалтаар ашигласан ус, рашаан тэдгээрийн орчинд төлбөр ногдуулна:

6.1.1.хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус;

6.1.2.уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус;

6.1.3.эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан рашаан;

6.1.4.эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны орчин.

7 дугаар зүйл. Ойн нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

7.1.Аливаа зориулалтаар ойгоос бэлтгэж ашигласан бүх төрлийн хэрэглээний мод, түлээнд төлбөр ногдуулна.

7.2.Ойн дагалт баялгийн нөөц самар, мөөг, давирхай, шилмүүс, мөчир, үр, хусны шүүсэнд төлбөр ногдуулна.

8 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

8.1.Төлбөр ногдох зүйл нь дор дурдсан зориулалтаар ашигласан ан амьтан байна:

8.1.1.ахуйн зориулалтаар агнасан, барьсан;

8.1.2.үйлдвэрлэлийн зориулалтаар агнасан, барьсан;

8.1.3.тусгай зориулалтаар агнасан, барьсан /соёл, шинжлэх ухаан, тусгай төлбөртэй/.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТӨЛБӨР ТООЦОХ ҮЗҮҮЛЭЛТ, ТЭДГЭЭРИЙГ ТОДОРХОЙЛОХ

9 дүгээр зүйл. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт

9.1.Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг ургамлын тухайн үеийн жинг килограммаар илэрхийлсэн нэгж дэх тухайн зүйл ургамлын тоо, хэмжээг тооцоолсон экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар тооцно.

10 дугаар зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт

10.1.Усны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлно:

10.1.1.усан цахилгаан станц, усан замын тээвэр, усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх, аялал зугаалга, биеийн тамир зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус, усан орчин ашигласан тохиолдолд тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс;

10.1.2.хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр;

10.1.3.уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр.

10.2.Рашаан ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлно:

10.2.1.эмчилгээ, сувилгааны зориулалтаар рашаан ашигласны төлбөрийг эмчлэн сувилуулсан хүн-хоногийн тоогоор;

10.2.2.үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар рашаан ашигласны төлбөрийг шоо метрээр.

11 дүгээр зүйл. Ойн нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт

11.1.Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг дор дурдсан үзүүлэлтээр тооцно:

11.1.1.ургаа мод огтолж, түүний үндсэн хэсгээс бэлтгэсэн хэрэглээний мод, түлээг нягт шоо метрээр, үзүүр, мөчрийг сийрэг шоо метрээр;

11.1.2.ойгоос хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүүг цэвэрлэж түлээ бэлтгэхэд сийрэг шоо метрээр.

11.2.Ойн дагалт баялгийн нөөцийг бэлтгэхэд хусны шүүсийг литрээр, бусад ойн дагалт баялгийн нөөцийг килограммаар тооцно.

12 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт

12.1.Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг дараах үзүүлэлтээр тооцно:

12.1.1.үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийг килограммаар;

12.1.2.ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих иргэнээс төлбөрийг агнасан, барьсан шувуу, загасны ширхгээр;

12.1.3.ахуйн зориулалтаар агнах бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээгээр;

12.1.4.ан амьтныг амьдаар нь барьж эзэмшин, гаршуулан үржүүлж, эмийн болон бусад түүхий эд бэлтгэж ашигласны төлбөрийг борлуулалтын орлогоор;

12.1.5.ан амьтныг амьдаар нь төрөөс худалдан авч өмчилсний төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээгээр;

12.1.6.гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтны төлбөрийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнээр.

13 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэг, түүний төрөл

13.1.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид “төлбөрийн орлогын хэсэг“ гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана.

13.2.Төлбөрийн орлогын хэсгийг дор дурдсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлнэ:

13.2.1.байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого;

13.2.2.ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого;

13.2.3.ойн нөөц ашигласны төлбөрийн орлого;

13.2.4.ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого;

13.2.5.газрын нөөцийн төлбөрийн орлого.

13.3.Ашигт малтмалын нөөц ашигласны болон байгаль орчныг бохирдуулсны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн хувь, хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

13.4.Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

13.5.Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ

14 дүгээр зүйл. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

14.1.Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний дор дурдсан хувиар тооцон төгрөгөөр тогтооно:

Төлбөр ногдох байгалийн ургамал	Төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний хувь	
	доод	дээд
1. Нэн ховор	25	30
2. Ховор	15	20
3. Элбэг	5	10

14.2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 14.1-д заасан төлбөрийн хэмжээний хязгаарт багтаан ургамлын нөөц, тархац, ач холбогдол, ашиглагдах эрхтний онцлог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан ургамлын нэр төрөл тус бүрээр төлбөрийн хэмжээг тогтооно.

15 дугаар зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

15.1.Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг энэ хуулийн 10.1-д заасан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

Төлбөр ногдох ус	Төлбөрийн хязгаар / экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар/			
	Гадаргын усанд		Газрын доорх усанд	
	доод	дээд	доод	дээд
1.Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	1	10	5	20
2.Хүнд үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	40	20	50
3.Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	30	20	60

4.Авто зам, засварт ашигласан усны шоометр тутамд	10	30	20	70
5.Хөнгөн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	30	10	40
6.Хүнсний үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд:				
а/Архи, пиво, согтууруулах ундаа	10	40	20	40
б/Ундаа, цэвэр ус	10	30	10	20
в/Талх, чихэр, нарийн боов, бусад	1	10	1	20
7.Уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд:				
а/ашигт малтмал олборлох, баяжуулах	10	40	20	60
б/зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах	10	50	20	70
в/усыг шавхан зайлуулах	10	15	15	50
г/эрэл, хайгуулын өрөмдлөг хийх	10	30	20	50
8.Эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	15	15	30
9.Газар тариалангийн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд	1	20	10	40
10.Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усны шоометр тутамд	10	30	15	50

Төлбөр ногдох ус	**Үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс тооцох төлбөрийн хязгаар /хувиар/**	
	Гадаргын усанд	
	доод	**дээд**
11.Усан цахилгаан станц, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх	1	30
12. Усны түгээмэл тархацтай амьтан, ургамал үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, аялал зугаалга, усан спортын байгууламж	1	20

15.2.Рашаан ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 10.2-т заасан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

Төлбөр ногдох рашаан	**Хэмжих нэгж**	**Төлбөрийн хязгаар /төгрөгөөр/**			
		Халуун		**Хүйтэн**	
		доод	**дээд**	**доод**	**дээд**
1.Эмчилгээ, сувилгааны зориулалтаар ашиглахад	Хүн-хоног	100	500	50	400
2.Үйлдвэрлэлийн болон үйлчилгээний зориулалтаар ашиглахад	Шоо-метр	500	1500	1000	3000

15.3.Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг энэ хуулийн 15.1-д заасан хязгаарт багтаан Засгийн газар, рашаан ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 15.2-т заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.

15.4.Халуун рашааныг үндсэн ашиглалтад нь нөлөө үзүүлэхгүйгээр халаалтын зориулалтаар ашиглавал ногдуулах төлбөрийн хэмжээг тухайн орон нутгийн халаалтын хөлсний 50 хувиар тогтооно.

15.5.Байгалийн халуун усыг халаалтын зориулалтаар ашиглавал ногдуулах төлбөрийн хэмжээг тухайн орон нутгийн халаалтын хөлсний 50 хүртэл хувиар, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашиглавал ус ашигласны төлбөрийн 50 хүртэл хувиар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.

15.6.Энэ хуулийн 15.3, 15.5-д заасан төлбөрийн хувь, хэмжээг ус, рашааны нөөц, чанар, ашиглалтын хэлбэр, зориулалтыг харгалзан тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, онцлогтой уялдуулан ялгавартай тогтооно.

16 дугаар зүйл. Ойн нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

16.1.Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээнээс энэ хуулийн 11.1.1-д заасан хэрэглээний модонд 6.0-30.0 хувь, энэ хуулийн 11.1.2-т заасан түлээнд 2.0-10.0 хувиар тооцно.

16.2.Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ, бэлтгэж тээвэрлэх зай, модны төрлийг харгалзан энэ хуулийн 16.1-д заасан хязгаарт багтаан Засгийн газар ойн мужлал бүрээр ялгавартай тогтооно.

16.3.Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигладаг аж ахуйн нэгж, байгууллагын мод тээврийн зайг мод бэлтгэлийн талбайгаас доод агуулах хүртэл, агуулахгүй бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрсөн цэг хүртэл, төвлөрсөн цэггүй бол уг мод бэлтгэсэн талбайд хамгийн ойр орших сумын буюу аймгийн төв хүртэлх зайгаар тус тус тооцно.

16.4.Аж ахуйн нэгж, байгууллага хуш модыг тусгай зөвшөөрлөөр бэлтгэх тохиолдолд түүнд тухайн ойн бүс нутагт шинэс мод бэлтгэж ашиглахад ногдуулдаг төлбөрийг 3 дахин өсгөсөнтэй тэнцүү хэмжээний төлбөр ноогдуулна.

16.5.Ойн дагалт баялгийн нөөцийг ашигласны төлбөрийн хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

17 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

17.1.Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн доод, дээд хязгаарыг дараах байдлаар тогтооно:

17.1.1.үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийг килограмм тутамд 700-1000 төгрөгөөр;

17.1.2.ахуйн, үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнасан бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар;

17.1.3.ан амьтныг амьдаар барьж эзэмшин, гаршуулан үржүүлж эмийн болон бусад түүхий эд бэлтгэж ашигласны төлбөрийг уг түүхий эдийн борлуулалтын орлогын 10-20 хувиар;

17.1.4.ан амьтныг амьдаар нь төрөөс худалдан авч өмчилсний төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи эдийн засгийн үнэлгээний 90-100 хувиар;

17.1.5.гадаадын иргэнд агнуулсан ан амьтны нөөцийн төлбөрийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 80-90 хувиар;

17.1.6.амьдаар нь гадаад оронд гаргасан ан амьтны төлбөрийг гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 80-90 хувиар.

18 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хувь, хэмжээ

18.1.Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	**Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/**
1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	15 хувь
2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь
3.Газрын нөөцийн төлбөрийн орлого	15 хувь
4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35 хувь

/Энэ хэсэгт 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

~~18.2.~~*/Энэ хэсгийг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

ТАВДУГААР БҮЛЭГ

ТӨЛБӨРӨӨС ЧӨЛӨӨЛӨХ, ХӨНГӨЛӨХ

19 дүгээр зүйл. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

19.1.Дараах зориулалт, хэрэгцээгээр байгалийн ургамлын нөөц ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө:

19.1.1.элбэг ургамлыг ахуйн хэрэгцээнд ашигласан иргэн;

19.1.2.ховор болон элбэг ургамлыг судалгаа шинжилгээний зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

19.1.3.байгалийн ургамлыг хадлан бэлчээрийн зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага.

19.2.Элбэг ургамал ашигласны төлбөрийг хөнгөлж болох бөгөөд төлбөрийг хөнгөлөх нөхцөл, болзол, хувь, хэмжээг тухайн орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

20 дугаар зүйл. Усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

20.1.Дараах зориулалтаар ус ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө:

20.1.1.хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах;

20.1.2.түймэр унтраах болон байгалийн бусад гамшигтай тэмцэх;

20.1.3.усыг үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд эргүүлэн ашигласан.

20.2.Дараах зориулалтаар ус ашигласан төлбөр төлөгчийн төлбөрийг Засгийн газраас тогтоосон хувь, хэмжээгээр хөнгөлж болно:

20.2.1.унд, ахуйн зориулалтаар усны эрдэсжилт, хатуулгыг нь цэнгэгжүүлж зөөлрүүлэн ашигласан;

20.2.2.ан амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, нутагшуулах болон ургамал тарьж ургуулах замаар байгалийн баялгийг нөхөн сэргээх;

20.2.3.хаягдал ус цэвэрлэж, эргүүлэн ашигласан тохиолдолд тухайн хэмжээгээр;

20.2.4.цас, бороо, үерийн усыг хуримтлуулж мал аж ахуй, газар тариалангийн зориулалтаар ашигласан.

21 дүгээр зүйл. Ойн нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

21.1.Хилийн бүсийн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч өөрийн албан ажлын байр барих зориулалтаар ойгоос хэрэглээний мод бэлтгэж ашигласан бол төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө.

21.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойд арчилгаа хийх, хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүү бэлтгэх зэрэг ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашиглавал төлбөрийг хөнгөлж болох бөгөөд хөнгөлөлтийн хувь, хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

22 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

22.1.Төлбөрөөс дараах тохиолдолд чөлөөлнө:

22.1.1.ан амьтныг нутагшуулан үржүүлэх зориулалтаар барих;

22.1.2.халдварт өвчний голомтыг устгах зорилгоор эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ан амьтныг мэргэжлийн байгууллагаас зохион байгуулалттай агнаж устгах;

22.1.3.мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах;

22.1.4.сорьц, дээж авах, хэмжилт хийх, им тэмдэг тавих, бөгжлөх, судалгааны хэрэгсэл зүүх зорилгоор ан амьтныг эрдэм шинжилгээний зориулалтаар түр барих.

22.2.Тодорхой нутаг дэвсгэрт ан амьтны тоог сийрэгжүүлэх, хүйсийн харьцааг зохицуулах, заазлах зорилгоор болон соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнахад төлбөрийг 80 хувь хүртэл хөнгөлж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТӨЛБӨР НОГДУУЛАХ, ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ

23 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөх

23.1.Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна.

23.2.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ.

23.3.Сум, дүүргийн Засаг даргын томилсон төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан төлбөрийг бэлнээр хураан авсан тухай бүр сум, дүүргийн төсөвт тушаана.

24 дүгээр зүйл. Төлбөрийн жилийн тайлан гаргах

24.1.Төлбөрийн жилийн тайланг дор дурдсан хугацаанд гаргана:

24.1.1.ургамал, ус, ой, ан амьтны нөөц ашигласны төлбөр хураан авах эрх бүхий албан тушаалтан төлбөрийн тайлангаа дараа оны 01 дүгээр сарын 1О-ны өдрийн дотор сум, дүүргийн татварын албанд;

24.1.2.сум, дүүргийн татварын алба тайлангаа дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн татварын албанд;

24.1.3.аймаг, нийслэлийн татварын алба тайлангаа дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад;

24.1.4.татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төлбөр, улсын нэгдсэн тайлангаа дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

24.2.Төлбөрийн тайлангийн маягтын загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

25 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

25.1.Энэ хуулийн 23.3-т заасныг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төлбөр хураах эрх бүхий албан тушаалтанд татварын байцаагч дараах захиргааны шийтгэл ногдуулна:

25.1.1.төлбөрийг аваагүй буюу дутуу авсан, төлбөрийн данс бүртгэл, баримтыг будлиантуулсан, хураан авсан төлбөрийг төсвийн орлогод тогтоосон журмын дагуу тушаагаагүй бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

25.2.Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувь, хэмжээг бууруулсан, төлбөрийн орлогын хэсгийг өөр зориулалтаар ашигласан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлнэ.

25.3.Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн төлбөр төлөгчид Татварын ерөнхий хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ